



# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 1. Бахархал бүхнийг оршоосон “Төмөрбулаг сум” бидний бахархалт нутаг

Хан Эрчим уулсынхаа өвөр бэлийг түшиж, хатан Бүгсийн голынхоо нуга хөндийд суурьшин, жаран жаран зуунд жаргах ерөөлтэй нутаг, Жаргалант хэмээн нэрлэгдсэн газарт сумынхаа шавыг тавьж, гал голомтоо бадраасан Төмөрбулаг сум нь 252172 га талбай бүхий нутаг дэвсгэртэй, Хөвсгөл аймгийнхаа урд зүгт оршдог. Тус сумын төв нь далайн түвшнээс дээш 1790 м өргөгдөсөн, газар нутгийн хамгийн өндөр цэг нь Дашдэрчин хайрхан далайн түвшнээс дээш 2556 метр өндөр өргөгдсөн, хамгийн нам дор цэг нь Олон голын бэлчир далайн түвшнээс 1148 м өргөгдсөн. Хангайн нурууны салбар Эрчим, Бүгсийн нурууны орчин газар нутаг, Дэлгэр мөрөн, Идэр голын ай сав газарт хамаарагдах Бүгсий, Бүгдгээний гол нутгаар байрладаг. Эрт дээр үеэсээ сонин содон тогтоц бүхий уул ус мөрнүүдтэй, олон зүйл төрлийн ан амьтан, мод ургамалтай байгалийн үзэсгэлэнт газруудтай, нутгийн шилмэл үүлдэр, угшлын 5 хошуу малыг өсгөн үржүүлдэг эх орны бахархалт түүхийн өлгий нутаг.

*Уул ус нь тэгширсэн нутаг*

*Ургамал ногоо нь сугсарсан нутаг*

*Араатан жигүүртэн элбэг нутаг*

*Ан амьтнаар баялаг нутаг*

*Уртын дууны шуранхайтай нутаг*

*Хурдан хүлгийн тоостой нутаг*

*Хүчит бөхчүүдийн аатай нутаг*

*Эрчит нумын уухайтай нутаг*

*Түүхэнд тод мөртэй Хотгойд зоны өлгий*

*Төмөрбулагчууд бидний сэтгэлд өнө мөнхөд орших  
бахархалт нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 2. Эх орноо хамгаалсан эрэлхэг баатруудын өлгий нутаг нэгэн бахархал

Хотгойдын Шадар ван Чингүнжав “Төр үр хоёр минь мөнх оршиг” гэсэн захиасыг биелүүлэхийн төлөө Хотгойд түмэн шантралгүй тэмцсээр ирсэн юм. Хөвсгөл аймгийн Монгол Улсндөрвөн баатрынхоёр нь Төмөрбулаг сумаас төрж гарсан байдаг. Монгол Улсын баатар хилчин Лхүнрэвийн Даваадорж Төмөрбулаг сумын 1 дүгээр багийн нутаг Донхорын голд төрж өссөн, 20 настайдаа эх орноо хамгаалахаар эр цэргийн албанд мордож, Ховдын Булган сумын нутаг Бүдүүн харгайтад 1948 оны долдугаар сарын 7-нд 130 гаруй хүнтэй Гоминданы зэвсэгт дээрэмчдийг эсэргүүцэн тулалдаж эх орноо халуун амь бүлээн цусаараа хамгаалсан энэ нутгаас төрсөн эрэлхэг зоригт хилчин баатар юм. Монгол Улсын баатар, гавьяат нисгэгч, Дугарын Гунгаа нь Төмөрбулаг сумын 4 дүгээр багийн нутаг Хаахайн сайр гэдэг газар мэндэлжээ. Эх орноо хамгаалах гурван дайнд оролцож, агаарт түмэн цаг илүү нисэж, энх цагт Иргэний агаарын тээврийг хөгжүүлэх үйлсэд амьдралынхаа 40 гаруй жилийг зориулсан эх оронч эрэлхэг зоригт, нисгэгч баатар юм. Төмөрбулаг сумын төвд Монгол Улсын Баатар Лхүнрэвийн Даваадорж, Дугарын Гунгаа нарын гэрэлт хөшөө сүндэрлэж “Энэ орон чинь эзэнтэй, эзэн нь эрэмгий зоригтой юм шүү” гэдгийг олонд сануулсаар байна.

*Үндэсний баатар шадар ван Чингүнжавын морин туурайн тамгатай*

*Үнэнч дайчин баатруудыг нь өлгөйдөж өсгөсөн нутаг*

*Хилчин баатар Даваадоржийн бойтогны мөртэй нутаг*

*Нисгэгч баатар Гунгаагийн нэрийг нь мөнхжүүлсэн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 3. Номч, мэргэд нь алдартай, шашин номын авшиг шингээсэн нутаг нэгэн бахархал

Тэртээ 1736 онд Төмөрбулаг сумын 4 дүгээр багийн нутагт Бүгсийн хүрээ хэмээн хожмоо Халх даяар алдарших их хүрээг байгуулж байсан түүхтэй аж. Бүгсийн хүрээ 15 сүм дуган, 16 жасын байшинтай, лам хуваргууд суух 200 гаруй хашаа байшинтай, 800-900 лам шавилан суудаг томоохон суурин газар хувьсгалт засагтай золгосон гэдэг. Тус сумын 3 дугаар багийн нутагт 1757 онд Бүгдгээний хүрээ байгуулагдаж, Цогчин дуганы хурлыг үүсгэсэн гэж түүхийн сурвалжид тэмдэглэгдсэн байна. Энэ хүрээ хийд нь 5-6 сүм дугантай, 200 гаруй лам хуврагтай, эрдэм чадалтай лам нартай энэ нутгийн шашны 2 дахь томоохон төв байжээ. Энэхүү хүрээ хийдүүдэд гүн ухаан Чойрын, анагаахын Мамба дацангаас эхлээд одон орон, зурхайн ухаан судлах Дуйнхор-Ивамдитанчойнхорлин дацантай, олон арван эрдэмтэн багш нартай, номын буян шингэсэн газар орон байжээ. Шүншиг, авшиг оршсон энэ л нутгаас эдүгээ цагийн олон арван эрдэмтэн мэргэд төрөн гарсан юм. Тухайлбал: Бүгдгээний хүрээнээс үе уламжлан төрсөн олон номч эрдэмтдийн нэг нь Монгол Улсын 25 дахь Ерөнхий сайд С.Баярын аав, эрдэмтэн, доктор Лувсангийн Санжаа, Санжаа гуайн аав Лувсан гэж олноо хүндлэгдсэн эрдэм ном ихтэй, гүрэмч, хувилгаан хүн байсан гэдэг.

*Жалханз хутагт гэгээнтний гэрийн буурьтай  
Шашны номч мэргэдээрээ нэр нь түгсэн нутаг  
Хоймор нутгийн бахархал төр, түмний түшээ  
25 дахь Ерөнхий сайдыг өлгийдөж авсан нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 4. Удам дагасан урчуудад авьяасыг өвлүүлсэн нутаг нэгэн бахархал

Энэ нутгийн урчуудын хийц нь Нийслэл хүрээ төдийгүй халх даяар алдаршиж байжээ. Өвгөддээдсээсээ гарын урыг өвлөж, ур ухаанаа үе дамжин өвлүүлж ирсэн түүхэн уламжлалтай. Хотгойд таван хошуунд харьяалагдсан Далай гүн, Мэргэн гүний урчууд нь өөрийн гэсэн дахин давтагдашгүй ур хийцтэй алт, мөнгө, үнэт эдлэл, төмрийн уран дархчуул нь нутаг хошуундаа алдартай байсан бол, үе дамжсан урчуудын дархан, баримал, сийлбэр, уран уран зургийн бүтээлүүд нь Монгол улсын соёлын өв, санд хадгалагдаж олон түмний хүртээл болсон байдаг. Монголын дүрслэх урлагийн их түүхийн төлөөлөл болсон уран барималч С.Дамдинжав, уран дархан Дамдинжавын Дорлиг, нэрт уран сийлбэрч Н.Лувсанцэрэн, түүний хүү уран зураач Лувсанцэрэнгийн Бат-Өлзий, ач хүү уран дархан, барималч Бат-Өлзийгийн Ганхөлөг гээд удам дамжсан алдартнууд энэ нутгийнх. Дүрслэх урлагт өөрийн гэсэн орон зай бүтээлээ тодоор үлдээсэн нэрт сийлбэрч Н.Лувсанцэрэнгийн бүтээлүүд өдгөө Монголын уран зургийн галерейд 14 бүтээл, МУЭ-ийн алтан сан хөмрөгт 6 бүтээл, Хөвсгөл аймгийн музейд 17 бүтээлүүд олны хүртээл болж хадгалагдаж байна. Мөн үндэсний эрх чөлөөний тэмцэгч ард Аюуш, Их зохиолч Д.Нацагдорж нарын монументаль хөшөөг хүрлээр цутган бүтээх их үйлсэд хүчин зүтгэж явсан С.Дамдинжавын “Аавын малгай” нэртэй хүрэл цутгуур өнөөдөр Монголын хосгүй үнэт бүтээлийн жагсаалтад багтдаг.

*Хоймор нутгийн ур, ухааныг гайхуулсан*

*Хосгүй урчуудаараа алдаратай нутаг*

*Улсынхаа соёлын өв санд давтагдашгүй бүтээл нь тавигдсан*

*Удам дамжсан урчуудад авьяасыг өвлүүлсэн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 5.Арван засгийн наадмаас алдар нэрээ дуурсгасан хүчтэнүүдийн нутаг нэгэн бахархал

Эрт дээр үеэсээ хошуу нутагтаа төдийгүй халх даяар алдартай олон хүчтэнүүд Төмөрбулаг сумаас төрсөн байна. Энэ нутагт 19 дүгээр зууны дунд үеэр Бүгсийн голоор нутаглаж байсан Бөрт хэмээх улсын арслан Дамдин, 19 дүгээр зууны эхэн үеэр Бүгдгээний голд нутаглаж байсан арван засгийн наадмын заан Наянтай, Даншигийн заан бороохой Дамдин нарын эгэлгүй хүчит бөхчүүдийн түүхэн замнал нь түүхийн эх сурвалж бичигт, бяр хүчний тухай аман хууч яриа нь ард түмний дунд домог болон өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн. Энэхүү хүчтэнүүдийн удмыг залгаж Ардын Хувьсгалын жилүүдэд бяр хүч, уран мэхийг гайхуулан барилдаж Монгол Улсын начин цолыг хүртсэн М.Эрдэнэбат, аймгийн арслан Ж.Гэлэгжамц, Б.Дан-Аа, З.Чимэдрагчаа, Л.Цэдэнсодном нарын тэргүүтэй олон арван хүчтэнүүд энэ нутагт мэндэлсэн байна. Төмөрбулаг суманд улсын арслан Бөрт Дамдины бяраа сорьж өргөж байсан 786 кг жинтэй чулуу өдгөөг хүртэл дурсгал болон хадгалагдаж, хүмүүсийн мэлмийг мялааж байна.

*Арван ес дүгээр зууны даншгийн заан Наянтайгийн төрж өссөн нутаг*

*Арван засгийн наадмын улсын арслан бөрт Дамдины домгийг өгүүлсэн нутаг*

*Ардын төрийн наадамдаа бяр хүчээ гайхуулж, алдар цолоо дуурсгасан*

*Монгол Улсын начин Эрдэнэбатыг өлгийдөж өсгөсөн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 6. Зуун дамжсан тахилгатай уулс хайрхануудын ховор тогтоцтой нутаг нэгэн бахархал

Тус сумын нутаг дэвсгэр нь Булнай нурууны дэд мужид хамаарагдах Эрчмийн нуруу, Анын нуруу, Бүгсийн нурууны томоохон уул, нуруудаар хүрээлэгдэн оршдог бөгөөд нэн эртний үеийн сонин содон тогтоц бүхий уулс ихээхэн байдаг. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 2556 м өргөгдсөн Дашдэрчин хайрхан юм. Төмөрбулагчуудын гол шүтээн болсон Дөш хайрхан, Баянзүрх, Чандмань, Дашдэрчин, Цог-Өндөр зэрэг өвгөд дээдсийн үеэс олон зууны турш уламжлан тахиж шүтэж ирсэн овоо тахилга бүхий байгалийн үзэсгэлэнт уул, овоог орон нутгийн амьдарч буй иргэд дээдлэн шүтэж байна. Баянзүрх хайрхны орой дээрээс долоон хошууны нутаг бүгд харагддаг хэмээн яригддаг.

*Долоон хошууны нутаг орой дээрээс нь харагддаг*

*Домогт мөнхөрсөн овоо хайрхнуудыг оршоосон нутаг*

*Дээдсийн үеэс шүтэгдсэн зуун дамжсан тахилгатай*

*Дашдэрчин, Урандөш, Баян зүрх, Чандмань хайрхнуудын хийморь тэтгэсэн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 7.Хатан “Сэлэнгэ мөрөн” эх авч урссан, “Олон гол бэлчир” – тэй байгалийн үзэсгэлэнт нутаг нэгэн бахарал

Төмөрбулаг сумын байгалийн үзэсгэлэн бүрдсэн усан сан бүхий газруудын нэг нь Олон голын бэлчир юм. Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн голууд болзсон юм шиг гурван талаас урсан ирж, хэлэлцсэн юм шиг нэгдсэн тэр л уулзвараас Сэлэнгэ мөрөн эх аван урсдаг. Тиймээс ч Олон голын бэлчир хэмээн нэрлэжээ. Үнэхээр ч өндөр уулс, ногоон моддоор хүрээлэгдсэн Олон голын бэлчрийг өндөр дээрээс харахад хэн нэгэн уран гартны ур ухаанаа шавхаж бүтээсэн хээ угалз мэт мөнгөлөгтөн харагдана. Тус суманд амралт аялал жуулчлалын отог бааз бүхий Бүгсий, Бүгдгээн зэрэг үзэсгэлэнт томоохон голууд, Төмрөөн булаг, Торц зэрэг хүний эрүүл мэндийг анагаах чанартай, рашаан ус зэрэг олон гол, мөрөн, харз, булаг усны нөөц байдаг.

*Хатан Сэлэнгэ мөрний эх болсон нутаг*

*Харь холын жуулчдын нүд булаасан нутаг*

*Олон гол, Бүгдгээний цутгалан, Торц, Төмрөөн булагийн рашаантай*

*Онгон дагшин байгальтай, үзэсгэлэн бүрдсэн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 8. Хүннүгийн үеийн түүхийг хадгалсан, өв соёлын дурсгалт нутаг нэгэн бахархал

Төмөрбулаг сум байгалийн үзэсгэлэн бүрдсэн түүх соёлын дурсгалт газрууд ихтэй бөгөөд нэн эртний үеийн чулуун болон хүрэл зэвсгийн үеийн булш хадны сүг зураг, буган чулуун хөшөөний түүхийн дурсгалт газруудтай. Тэдгээрийн нэг нь 4 дүгээр багийн нутагт байгаа 100-180 см-ын өндөртэй, 13 ширхэг буган хөшөөн дээр буга ан амьтанг тун ч гоёмсгоор сийлэн үлдээсэн “Зуна голын буган чулуун хөшөө”-нүүд юм. Уг хөшөөнүүдийг Засгийн гзарын тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан. Тус сумын нутагт тэнгэрт цогнойх Арслан хад, эгц өндөр уул руу гулсан бууж буй аварга том Могой хад, жигүүрээ дэлгэн нисэх гэж буй шувууны дүрс бүхий Хангарьд хад зэрэг сонин тогтоцтой дурсгалт газрууд олон бий.

*Хүннүгийн үеийн соёлын өвийг хадгалсан*

*Буган чулуун хөшөөний нутаг*

*Хоймор нутгийн түүхийн дурсгалт*

*Хотгойд зоны өлгий нутаг*







# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 9. Хошуу даяар алдартай хурдан адууны хийморь тэтгэсэн нутаг нэгэн бахархал

Төмөрбулаг сум нь эрт дээр үеэс эхлэн аймаг хошуундаа алдар цуутай хурдан хүлгүүдтэй байсан бөгөөд хурдан хүлгүүд нь ихэвчлэн бор, улаан, саарал зүсмийн морьдууд байсан учраас Төмөрбулагийн хурдан саарлууд гэж алдаршиж байжээ. АХ-ын ын 84 жил, Төмөрбулаг сум байгуулагдсаны 80 жилийн ойн баярын их насны морьдын уралдааны шөвгийн таван морь нь тус сумын уяачдын хурдлуулсан таван цагаан бор зүсмийн хүлгүүд байсан нь бэлэгшээлтэй. Зарим хурдан адуу судлаачид Хотгойдын хонин бор адууны удам гэж үздэг. Ардын хувьсгалын жилүүдэд энэ сумын баяр наадмын хурдан их насны морины уралдаанд гадна аймаг, сумын морь түрүүлсэн түүх гарын 5 хуруунд багтах цөөхөн бөгөөд нутгийн хурдан хүлгүүд нь магнайдаа тоосгүй түрүүлсэн байдаг. Тус сумын хурдан ажнай хүлгүүдийн амжилтын түүхийг сөхвөл: 1930-1980 онын үед уяач Санжаа начин, Л.Байдай, Ж.Баадай, С.Баадай, Д.Гонгор, Н.Лувсанцэрэн, Н.Жамьяандорж, Н.Жамьяанрагчаа, Я.Ичинхорлоо, Д.Жамьяанжав, ЧДорж нарын тэргүүтэй олон уяачдын уясан хүлгүүд аймгийхаа наадамд түрүү, шөвөгт хурдалж байсан түүхтэй. 1990 оноос хойшхи Монгол Улсад хурдан морины спортын хөгжлийн жилүүдэд Монголын шигшмэл хурдан морины анхны “Их хурд” уралдаанд ААУ Ж.Хөрөнгөөгийн “Үүлэн бор” морь нь 7-д хурдалсан. ААУ Л.Оюун-Эрдэнийн Хүрэн халзан морь Эрдэнэтийн хангайн бүсийн хурдан морины даншигт 6-д, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 80 жилийн их насны морьдын уралдаанд түрүүлж, Б.Лигшигдоржийн Хонгор морь Хөвсгөл аймгийн анхны “Хотгойдын хурд” уралдаанд 3-аар давхиж, аймгийн наадамд уяж сойсон нутгийн угшилтай олон хурдан хүлгүүд түрүү, шөвөгт хурдалж, орон нутгийнхаа нэрийг дуурсгаж байна.

*Хурдан морины анхны даншиг наадмын түүхэнд тод мөрөө үлдээсэн*

*Хөрөнгөөн “Үүлэн бор” морины сунгааг тааруулсан нутаг Хотгойдын хурд, аймгийнхаа тэгш ойд торгон жолоо өргүүлсэн Оюун-Эрдэнийн Хүрэн халзан, Лигшигдоржийн Хонгор морины босоо төрсөн нутаг*





# ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРВАН БАХАРХАЛ

## 10. Хан Эрчим уулсаараа нэрлэгдсэн хар ямааг үүлдэр болгосон нутаг нэгэн бахархал

Төмөрбулагчууд эрт дээр үеэс нарийн ноолууртай, сүү махны гарц сайтай хөх зүсмийн ямааг үе дамжин малласаар иржээ. 1979 онд Горно-Алтай үүлдрийн ухна авчран үржүүлэгт оруулж ашигласнаар хөх ямаа хар зүстэй болсон гэдэг. Харин 1985 онд Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдэл 2-р багийн нутаг дэвсгэр дээр “Ямааны улсын үржлийн ферм” байгуулан ХАА-н эрдэмтэд, нутгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран ямаагаа ангилж, судалгаа хийжээ. Үүний үр дүнд хангайн бүсийн нөхцөлд нэн сайн зохицсон ноолуур махны чиглэлийн ямааг үржүүлсэн бөгөөд Төмөрбулагийн хар ямааг 1996 онд “Эрчим омог”-оор, “Эрчимийн хар ямаа”-г 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ХХААХҮ-ийн сайдын А/176 дугаар тушаалаар үүдрээр баталгаажуулсан байна. Эрчим” үүлдрийн хар ямааны 13.9-14.7 микрон голчтой ноолуураар хийсэн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд өндрөөр үнэлэгдэж чаддаг

*Эрчимийн өндөр хайрханд нь эрдэнэт сүрэг нь налайсан нутаг*

*Эрчим үүлдрийн хар ямаагаараа Дэлхийд данстай нутаг*

*Уул ус нь тэгширсэн нутаг*

*Ургамал ногоо нь сугсарсан нутаг*

